



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠤᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/60

Алтай хот

**Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог
 шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/190, А/280 дугаар тушаалаар баталсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ын 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн болон “Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль”-ийн үйлчлэлд хамаарахгүй гэрч хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэн, зөвлөгөө өгч эрх ашгийг нь хамгаалах чиг үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог хавсралтаар шинэчилэн баталсугай.

2.Хорооны үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган, үйл ажиллагааны тайланг жилд нэг удаа Хүүхдийн төлөө зөвлөлд тайлагнан ажиглахыг Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны даргад даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/23 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2023 оны 01
дугаар сарын 17-ны өдрийн 70 дугаар
захирамжийн хавсралт

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ
БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

(Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

(Шүүхийн Тамгын газрын дарга) (зөвшилцсөнөөр)

(Прокурорын газрын ерөнхий прокурор) (зөвшилцсөнөөр)

(Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн

бичгийн дарга) (зөвшилцсөнөөр)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн

хэлтсийн дарга)

(Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

(Эрүүл мэндийн газрын дарга)

(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

(Цагдаагийн газрын дарга)

(Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга)

(Өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга) (зөвшилцсөнөөр)

(Аймгийн Хүүхдийн элч) (зөвшилцсөнөөр)

(Хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус

байгууллагын төлөөлөл) (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)